



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 46/01

Арвайхээр сум

┌ Хуралдааны дэгд өөрчлөлт оруулах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.9 дэх хэсэгт заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1.Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 01/04 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэг”-ийн тав дахь бүлэгт доорх заалтыг нэмсүгэй.

1.1“5.16.Товлосон хуралдаан эхлэхээс өмнө болон хуралдааны үеэр байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиох, хууль эрх зүйн орчны тодорхойгүй байдал үүсэх зэрэг зайлшгүй нөхцөл байдал үүсвэл хэлэлцэх асуудлын дарааллыг өөрчлөх, үүссэн нөхцөл байдлыг арилах хүртэлх хугацаагаар хуралдааныг нээлттэй орхих эсвэл асуудлыг хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнөөс хасах талаар санал хураалт явуулж төлөөлөгчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.”

ДАРГА

Т.НАРАНГАРАВ